

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгмийн тухай хамгийн ерөнхий ойлголт аль нь вэ? (1 оноо)
 - A. Нийгэм бол амьдралыг цогцлуулж буй хүмүүсийн үйл ажиллагаа
 - B. Нийгэм бол нэг бүхэл болгон нэгтгэсэн хүмүүсийн тогтолцоо
 - C. Нийгэм, байгаль, соёл бол харилцан нөлөөлөлт зүйлс
 - D. Нийгэм бол хүн төрөлхтний эрхэм дээд эрмэлзлэлийн биежилт
 - E. Нийгэм нь хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт материаллаг болон оюуны үнэт зүйлсээ үйлдвэрлэн бүтээж, хэрэглэж, амь нас, эрүүл мэндээ хамгаалж, үр удмаа үлдээн амьдрах зайлшгүй орчин

2. Нийгмийн нийтлэгийн ойлголт аль нь вэ? (2 оноо)
 - A. Нийгмийн харилцааны тодорхой хүрээг зохицуулагч хэм хэмжээний цогц
 - B. Ястан, үндэстэн, угсаатнуудын үйл ажиллагааны цогц
 - C. Хүний салшгүй шинжүүдээр ижилссэн тогтвортой холбоо бүхий бие даасан байдлаар оршдог нийгмийн үйлдлийн тодорхой субъект болсон бүлэг хүмүүс
 - D. Тодорхой бүлгүүдийн хоорондын харилцан хамаарал бүхий нэгдэл
 - E. Аль нь ч биш

3. Нийгмийн бүлгийн ойлголт аль нь вэ? (1 оноо)
 - A. Ижил зорилго бүхий 6 доошгүй хүмүүсийн хамтын ажиллагаа
 - B. Нэг зорилго, ижил эрх ашиг, сонирхол, үнэт зүйл, зан үйл бүхий хүмүүсийн нэгдэл
 - C. Өөр өөр эрх ашиг, сонирхол бүхий хүмүүсийн нэгдэл
 - D. Нэг нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа хүмүүсийн цогц
 - E. Дээрхи бүгд

4. Хамт олны нийгэмд гүйцэтгэх үүрэгт аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)
 - A. Нийгэмд бие хүнийг төлөвшүүлж нийгэмшүүлэх
 - B. Төрийн хууль тогтоомж баталж гаргахад оролцдог
 - C. Нийгмийн хамтач ёсыг төлөвшүүлэх
 - D. Ардчилал, төрт ёсыг хөгжүүлж, түүний гол объект, субъект нь болдог
 - E. Оюуны болон материал баялгийг үйлдвэрлэн бүтээх, хуваарилах, түгээн дэлгэрүүлэх

5. Формацийн онолыг хэн боловсруулсан бэ? (1 оноо)

A. О. Шпенглер	B. Ж.Тойнби	C. К. Маркс
D. Н.Я. Данилевский	E. У.Ростоу	

6. Түүврийн аргын ангилалд тохирохгүй зүйл аль нь вэ? (1 оноо)
 - A. Санамсаргүй түүвэр
 - B. Системчилсэн түүвэр
 - C. Нэлэнхүйн түүвэр
 - D. Давхраажилсан түүвэр
 - E. Бүгд зөв

7. Индукцийн аргын мөн чанарт аль нь тохирох вэ? (2 оноо)
 А. Тусгай тусгай юм үзэгдлүүд, баримтуудаас ерөнхий үндэслэл дүгнэлт гаргах
 В. Ямар нэг онол, үндэслэл, ерөнхий дүгнэлт зэргээс түүнд холбогдох бүлэг юмуу, бодгаль зүйлд хамруулсан дүгнэлт хийх
 С. Бүх л зүйлийг бүрэлдэхүүн хэсэг, нэгжид нь сэтгэхүйдээ салган хувааж задлах
 D. Танин мэдэгдсэн нэгж, салангад хэсгүүдийг нэг цогцод оруулан сэргээн холбож нэгтгэн дүгнэх
 E. Нийгмийн үзэгдэл, үйл явцад судлаач өөрөө оролцох юм уу, оролцохгүй ажиглах замаар мэдээлэл цуглуулах
8. Нийгэмшилтэд илүү нөлөөтэй нь аль вэ? (1 оноо)
 А. Хүн амын суурьшил
 В. Нийгэм, соёлын орчин
 С. Байгалийн үзэсгэлэнт байдал
 D. Хөрөнгө чинээ
 E. Мэргэжил, боловсрол
9. Нийгмийн хамгааллын хүрээнүүдийг тоочиход илүүц зүйл аль нь вэ? (1 оноо)
 А. Эрүүл мэндийн даатгал
 В. Ажилгүйдлийн тэтгэмж олгох
 С. Ажлын байраар хангах
 D. Мэргэжил эзэмшихэд нь туслах
 E. Дээрх бүгд
10. Нийгмийн бүтцийг бүрдүүлж байгаа үндсэн элементүүдэд хамааралгүй нь аль вэ? (1 оноо)
 А. Социал статус
 В. Социал үүрэг
 С. Социал бүлэг
 D. Социал институт
 E. Социал эрх
11. Хүн нийгэмд, зан төлөвийн шинж, нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийг олж авахыг шинжлэх ухааны хэллэгт юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
 А. Бие хүн болж төлөвших
 В. Нийгэмшилт
 С. Нийгэмшлийн агент
 D. Нийгэмшлийн механизм
 E. Гэр бүл
12. Нийгмийн амьдралын зохион байгуулалт нь ураг төрлийн холбоонд тулгуурладаг нийгмийг гэнэ. (2 оноо)
 А. Газар тариалангийн
 В. Аж үйлдвэржсэн
 С. Цэцэрлэгжүүлэх
 D. Агнуурын болон түүвэрлэгчдийн
 E. Аж үйлвэржсэний дараах
13. Засгийн эрхийг гартаа авахын төлөө эрмэлзэх нь ямар хүчний зорилго вэ? (1 оноо)
 А. Олон нийтийн байгууллага
 В. Холбоо
 С. Улс төрийн нам
 D. Үйлдвэрчний эвлэл
 E. Иргэний хөдөлгөөн
14. Улс төр бол “төр улсын бүх ажил хэрэг” гэж хэн үзсэн бэ? (1 оноо)
 А. К. Маркс
 В. Р. Даль.
 С. Х. Лассуэл
 D. Аристотель
 E. Рассель
15. Улс төрийн засаглалын легитимт шинжийг олно уу. (2 оноо)
 А. Оновч муутай санаа бодол, сэтгэл хөдлөл дээр суурилсан засаглал
 В. Улс төрийн зүтгэлтний нэр хүнд, авъяас билэгт тулгуурлах явдал
 С. Засаглалыг нийгмийн зүгээс зөв зүйтэй гэж үзэн нийгмийг удирдах эрхтэй хэмээн зөвшөөрөх явдал
 D. Харьцангуй удаан хугацаанд оршин тогтнох засаглалын хэлбэр
 E. Засаглалыг хуваарилах

16. Улс төрийн мэдээлэл харилцааны дэд тогтолцооны чиг үүрэгт аль нь хамааралгүй вэ? (2 оноо)
 А. Төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах
 В. Иргэдийг мэдээлэл, мэдлэгээр хангах
 С. Мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хангах
 D. Намын үзэл суртлыг тулгах
 E. Иргэдийн улс төрийн сонголт хийх бололцоог хангах
17. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналыг УИХ-д аль субъект өргөн мэдүүлэх вэ? (1 оноо)
 А. Ерөнхийлөгч
 В. УИХ-ын дарга
 С. Үндсэн хуулийн цэц
 D. Ерөнхий сайд, ерөнхийлөгчтэй зөвшилцөн
 E. Улс төрийн намын дарга
18. Ардчиллын үнэт зүйлс аль нь вэ? (1 оноо)
 А. Иргэдийн оролцоо
 В. Эрх, эрх чөлөө, тэгш ёс
 С. Шударга ёс
 D. Чөлөөт, шударга сонгууль
 E. Бүгд зөв
19. Ерөнхийлөгчийн түр эзгүйд бүрэн эрхийг хэн хэрэгжүүлэх вэ? (1 оноо)
 А. Ерөнхий сайд
 В. УИХ дарга
 С. Олонхийн суудалтай намын дарга
 D. Үндсэн хуулийн цэцийн дарга
 E. Сангийн сайд
20. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг улс төрийн тогтолцоо аль нь вэ? (2 оноо)
 А. Авторитар
 В. Тоталитар
 С. Ардчилсан
 D. Аристократ
 E. Бюрократ
21. Улс төрийн намыг баримталж буй үзэл суртлын агуулгаар нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)
 А. Эрх баригч, сөрөг
 В. Зүүний, барууны, төвийг сахисан
 С. Социалист, консерватив, либерал
 D. Боловсон хүчний, олон түмний
 E. Хувьсгалт, уламжлалт
22. Өнөөгийн нийгэмд бусдаасаа орлого, боловсрол, эрх мэдэл, нэр хүндээрээ ялгаатай аливаа нийгмийн давхрааг гэнэ. (2 оноо)
 А. Нийгмийн тэгш байдал
 В. Үндэстэн
 С. Анги
 D. Маргиналууд
 E. Ядуучууд
23. Улс төрийн намын үндсэн шалгуурт аль нь тохирохгүй вэ? (2 оноо)
 А. Оршин тогтнох цаг хугацаа буюу удаан хугацаагаар оршин тогтнох чадвартай байх
 В. Засгийн эрхийн төлөө тэмцэх чадвартай байх
 С. Удирдах төв ба орон нутгийн байгууллагатай байх
 D. Олон улсын улс төрийн ямар нэгэн байгууллагад нэгдсэн байх
 E. Тодорхой мөрийн хөтөлбөртэй байх
24. Нийгмийн амьдралын бүх хүрээг хянадаггүй, эдийн засаг, хувийн амьдралын хүрээнд тодорхой хэмжээний эрх чөлөө олгож, нэгдмэл үзэл суртлыг тулгадаггүй дэглэм аль нь вэ? (2 оноо)
 А. Тоталитар
 В. Авторитар
 С. Ардчилсан
 D. Аристократ
 E. Бүгд

25. Холбооны улсаас нэгдмэл улсын ялгагдах онцлог юунд орших вэ? (2 оноо)
A. Төрийн аппаратын хоёр түвшинтэй байх
B. Бүрэн эрхт байдлын субъект нь ард түмэн
C. Иргэний хоёрдмол харьяалалтай байх
D. Татварын нэг тогтолцоотой байх
E. Олон шашинтай байх
26. “Амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдал” гэсэн ойлголт аль нь вэ? (1 оноо)
A. Харьцангуй ядуурал B. Ядуурлын босго C. Үнэмлэхүй ядуурал
D. Аль нь ч биш E. Амьдралын гачигдал
27. Боломжит хувилбаруудаас сонгосон бараа, үйлчилгээг ямар түүхий эд, технологиор, хэнээр хийлгэх нь аль асуудалтай холбоотой вэ? (2 оноо)
A. Хэнд зориулан үйлдвэрлэх вэ? B. Эдийн засгийн үйл явц
C. Яаж үйлдвэрлэх вэ? D. Юу үйлдвэрлэх вэ?
E. Аль алинд нь хамаарахгүй
28. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд дараах зүйлүүдийн аль нь бараа, үйлчилгээ үйлдвэрлэхэд гол хөшүүрэг болдог вэ? (2 оноо)
A. Бараа, үйлчилгээг худалдан авах B. Буяны хандив өгөх
C. Ашиг олох D. Аюулгүй байдлыг хангах
E. Эрсдлийг дагуулах
29. Инженер Д. Цогтсайхан үйлвэрлэлийн шат дамжлагыг хялбаршуулж цөөлсөн суурь машин зохион бүтээж зохиогчийн эрхийн патент авчээ. Энэ нь өмчийн илрэх ямар хэлбэр вэ? (1 оноо)
A. Биет байдал B. Биет бус байдал C. Хэрэглэх
D. Аль аль зөв E. Аль аль нь биш
30. Зах зээлийн бүтцийг өрсөлдөөний байдлаар нь юу гэж ангилдаг вэ? (2 оноо)
A. Үйлдвэрлэлийн ба хэрэглээний зах зээл
B. Олигополь ба монополь зах зээл
C. Төгс ба төгс бус өрсөлдөөний зах зээл
D. Бөөний ба жижиглэнгийн зах зээл
E. Бүгд буруу
31. Инфляци өсөхөд гарах сөрөг үр дагавар аль нь вэ? (1 оноо)
A. Бизнесийн орчин муудах B. Хүмүүсийн төлбөрийн чадвар доройтох
C. Ядуурал, ажилгүйдэл өсөх D. Эдийн засгийн өсөлт буурах, зогсох
E. Бүгд зөв
32. Төв банкны гол үүрэгт аль нь багтах вэ? (1 оноо)
A. Олон улсын банкуудтай холбоотой ажиллах
B. Мөнгөний бодлого хэрэгжүүлэх
C. Мөнгөн хадгаламж авах
D. Худалдааны газруудтай тооцоо хийх
E. Бүгд зөв
33. Хүмүүс ажлын байраа сайн дураараа солих, улирлын чанартай ажил эрхлэх нь ажилгүйдлийн аль хэлбэрт хамаарагдах вэ? (1 оноо)
A. Бүтцийн ажилгүйдэл B. Шилжилтийн ажилгүйдэл
C. Мөчлөгийн ажилгүйдэл D. Ажилгүйдлийн түвшин
E. Байнгын ажилгүйдэл

34. Эд хөрөнгийг шууд мэдэлдээ байлгаж эдлэх боломжтой байхыггэнэ. (2оноо)
 А. Ашиглах В. Захиран зарцуулах С. Эзэмших
 D. Хэрэглэх E. Түрээслэх
35. Мөнгөний түүхэн хэлбэрүүдийг дурдахдаа илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Тавааран мөнгө В. Алт мөнгөн зоос С. Цаасан мөнгө
 D. Зээлийн мөнгө E. Өртөг
36. Өрсөлдөөн гэж юу вэ? (2 оноо)
 А. Өөрсдийн нөлөөгөө өргөжүүлэхийн төлөө аж ахуйн нэгж, компаниудын явуулж буй тэмцэл
 В. Аж ахуйн нэгж, хүмүүсийн өөрсдийн ашиг сонирхолоо дээд зэргээр хангахын тулд бие биенээсээ урьдаж амжуулах гэсэн тэмцэл, эрмэлзэл, бодит үйл ажиллагаа юм
 С. Улс оронд нөлөө болох томоохон компаниудын хоорондын болон олон улсын зах зээлд гарах гэсэн тэмцэл
 D. Зах зээлд оролцогчдын хооронд үйлдвэрлэл болон бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах талаар бусдаас давуутай нөхцлийг олж авахын төлөө явагдаж байгаа тэмцэлдээнт харилцаа
 E. Дээрх бүгд
37. "Давхраажил"-ын агуулгыг А. Гидденс хэрхэн тодорхойлсон бэ? (1 оноо)
 А. Тэгш биш байдлын туйлын хэлбэр
 В. Хүмүүсийн бүлгүүдийн хоорондын бүтэцжсэн ялгаа
 С. Нийгмийн бүлгүүдийн нэр хүндийн ялгаа
 D. Хүмүүсийн орлого ба баялгийн түвшиний ялгаа
 E. Хүмүүсийн бүлгүүдийн хоорондын соёлын ялгаа
38. Дараах хэмжигдэхүүнээс аль нь илүүц вэ? (1 оноо)
 А. Эд баялаг ба орлого В. Нэр хүнд С. Эрх мэдэл
 D. Боловсрол E. Шударга ёс
39. Социализмын үеийн монголын нийгмийн анги давхрааг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)
 А. Ажилчин В. Хоршоолсон ард С. Менежер
 D. Сэхээтэн E. Бүгд зөв
40. Нийгмийн давхрааны ялгаанд аль нь голлох хамааралтай вэ? (1 оноо)
 А. Нас, хүйс В. Албан тушаал, цалин, орлого С. Суурьшил
 D. Алдар нэр, хүндэтгэл E. Намын харъяалал
41. Аль нь төрөлх статус вэ? (1 оноо)
 А. Миний ээж буриад ястан В. Ах маань оюутан
 С. Дорж хуульч хийж байгаа D. Дүү 6 нас хүрч сургуульд оров.
 E. Боксчин Бадар-Ууган гавъяат болов
42. Хүн төрмөгцөө багтдаг насан туршдаа өөрчилж болдоггүй нийгмийн бүлэг, давхраа аль нь вэ? (1 оноо)
 А. Ажилчин В. Тариачин С. Каст D. Сэхээтэн E. Феодал
43. Аль нь соёлын элемент вэ? (1 оноо)
 А. Нийгэм В. Үнэлэмж С. Төр D. Өмч E. Бүгд буруу
44. Соёлыг илрэх байдлаар нь хэрхэн ангилдаг вэ? (1 оноо)
 А. Эдийн,оюуны соёл В. Соёлын хямрал, түрэмгийлэл
 С. Соёлын нэгдэл, хуримтлал D. Соёлын даяаршил, зөрчил E. Бүгд зөв

45. Элитийн соёлын онцлогийг тэмдэглэнэ үү. (2 оноо)
А. Язгууртан дээдэс, эрх ямбатай хангалуун хэсэгт зориулагдсан
В. Ард түмний оюуны эрэл хайгуулыг илэрхийлдэг
С. Нийгмийн бүх давхаргад хүртээмжтэй байдаг
D. Нийгэмд зонхилж буй соёлтой зөрчилдөж байдаг
E. Бүгд буруу
46. Соёлын үүргүүдийг тоочиход аль нь илүүц вэ? (1 оноо)
А. Соёлын хүмүүжил- боловсролын үүрэг
В. Соёлын нэгтгэгч ба салгагч үүрэг
С. Соёлын тухай туршлага, мэдээллүүдийг соёлын байгууллагуудад арилжаалах
D. Соёлын зохицуулагч үүрэг
E. Бүгд зөв
47. Аливаа хэм хэмжээг биелүүлснийх нь төлөө урамшуулах үйл явцыг аль нь илэрхийлж байна вэ? (2 оноо)
А. Санкци
В. Дэмжих санкци
С. Хориглох санкци
D. Хэм хэмжээ
E. Зуршил
48. Нийтийн соёлын онцлог аль вэ? (1 оноо)
А. Язгууртан дээдсийн таашаалыг илэрхийлдэг
В. Ард түмний оюуны эрэл хайгуулыг илэрхийлдэг
С. Нийгмийн бүхий л давхаргад хүртээмжтэй байдаг
D. Нийгмийн хангалуун амьдралтай хэсгийн төлөөлөгчдөд зориулагддаг
E. Бүгд буруу
49. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний хэрэгцээг хангахад туслах, хүүхдийн бүхий л чадавхи, бололцоог хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага аль нь вэ? (1 оноо)
А. ЮНИДО
В. ЮНЕСКО
С. ЮНИСЕФ
D. ОУВС
E. АСЕАН
50. Олон улсын түгээмэл шинжтэй байгууллага НҮБ хэдэн онд байгуулагдсан бэ? (1 оноо)
А. 1939-11-08
В. 1942- 11-15
С. 1945-10-24
D. 1949-10-28
E. 1947-11-02
51. Олон улсын харилцааны хүмүүнлэгийн салбарт аль үйл ажиллагаа нь хамаарах вэ? (2 оноо)
А. Нээлттэй далай тэнгист чөлөөтэй зорчих
В. Үндэсний төр улсуудын агаарын хилийг хүндэтгэх
С. Ядуурал, өлсгөлөнг арилгах, гамшиг тохиолдсон нөхцөлд туслах
D. Цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх
E. Шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх
52. НҮБ-ын төрөлжсөн байгууллагад орохгүй байгууллага аль нь вэ? (1 оноо)
А. Эдийн засаг, нийгмийн зөвлөл
В. Хүүхдийн сан
С. Дэлхийн банк
D. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
E. Олон улсын хөдөлмөрийн байгууллага
53. Эрх зүйн этгээд аль нь вэ? (2 оноо)
А. Эрх зүйн бүрэн чадамжтай, нас биед хүрсэн иргэд
В. Албан ёсны байгууллага, аж ахуйн нэгж
С. Төр
D. Тусгаар тогтносон улс
E. Бүгд зөв

54. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь үндсэн дээр хэрэгжинэ. (2 оноо)
 А. Төрийн удирдлагын В. Нутгийн өөрөө удирдах ёсны
 С. Иргэдийн оролцоо, нутгийн өөрөө удирдах ёсны
 D. Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах
 E. Дээрх бүгд
55. Монгол улсын иргэн хүний журамт үүрэг аль нь вэ? (1 оноо)
 А. Хууль дээдлэн сахих В. Татвар төлөх С. Эх орноо хамгаалах
 D. Байгаль орчноо хамгаалах E. Бүгд зөв
56. Үндсэн хуулинд шашин, төрийн харилцааг зөв томъёолсон өгөгдөл аль нь вэ? (2 оноо)
 А. Шашин нь төрөө хүндэтгэнэ, төр нь шашинаа мандуулна
 В. Төр шашин аль алианаа хүндэтгэнэ
 С. Төр нь шашинаа хүндэтгэнэ, шашин нь төрөө дээдлэнэ
 D. Төр нь шашинаа, шашин нь төрөө дээдэлж, хүндэтгэнэ
 E. Төр нь шашнаа хүндэтгэж, шашин төрөө хүндэтгэнэ

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)
 (a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|-------------------|--|
| a. Гэр бүл | 1. Гэр бүлийн засаглалын тогтолцоонд эхнэр юмуу эх голлох үүрэгтэй оролцох |
| b. Эцгийн эрхт ёс | 2. Гэрлэлтийг тодорхой бүлгийн дотоодод нь баталгаажуулдаг ёс |
| c. Эхийн эрхт ёс | 3. Гэрлэлтийг тодорхой бүлгээс үл хамааруулан зохицуулах ёс |
| d. Экзогами ёс | 4. Гэр бүлийн гишүүдийг эрэгтэй хүн удирдаж засаглах байдал |
| e. Эндогами ёс | 5. Цусан төрөл, гэрлэлт, үрчлэлт, аж амьдрал зэргээр холбогдож, үр хүүхдийнхээ хүмүүжилд харилцан хариуцлага хүлээдэг хүмүүсийн нэгдэл |

- 2.2 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)
 (a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|----------------------------------|---|
| a. Бүх нийтийн зарчим | 1. Сонгогч хэний ч нөлөөнд автахгүй, зөвхөн өөрийн ухамсартай үйл ажиллагаагаар бие дааж саналаа илэрхийлэх боломж |
| b. Чөлөөтэй сонгох зарчим | 2. Нэг сонгогч нэг л удаа саналаа гаргах, сонгогчид саналын эрхтэй байх, сонгогч бүрийн саналын хувийн жин ижил байх, нэг тойрог дах сонгогчийн тоо тэгш байх нөхцөл |
| c. Шууд сонгох зарчим | 3. Иргэн хүн ямар нэгэн төлөөлөлгүйгээр өөрөө саналаа гаргаж сонгуулийн эцсийн дүн тодорхойлогдох явдал |
| d. Саналаа нууцаар гаргах зарчим | 4. Тухайн улсын сонгуулийн насанд хүрсэн, эрх бүхий нийт иргэн сонгуульд өргөнөөр оролцож саналаа илэрхийлэх боломж |
| e. Тэгш эрхийн зарчим | 5. Сонгуульд оролцох, эс оролцох, хэний ч дарамт шахалтад оролгүйгээр саналаа чөлөөтэй илэрхийлэх, нэр дэвшигчдийг бүгдийг татгалзах, сонгуулийн үйл явц, сонголт хийх боломж нь өргөн байх явдал |

2.3 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)

(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|--------------------------------------|---|
| a. Сонгууль | 1. Парламентийн суудлын тодорхой хэсгийг мажоритар системээр, үлдсэн хэсгийг пропорционал системээр хуваарилах арга |
| b. Сонгуулийн систем \ өргөн утгаар\ | 2. Сонгогчид намын төлөө саналаа гаргадаг бөгөөд сонгуулиар улс төрийн намуудын авсан саналын тоотой хувь тэнцүүлэн парламентын суудлыг намуудад хуваарилдаг систем |
| c. Мажоритар | 3. Сонгуулийн эрх, сонгуулийн зарчим, сонгуулийн дүнг гаргах, суудал хуваарилах арга зэргийг тодорхойлсон хэм хэмжээний цогц |
| d. Пропорционал | 4. Сонгогчид зөвхөн нэр дэвшсэн хүний л төлөө саналаа гаргадаг бөгөөд өрсөлдөгчөөсөө хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцдог систем |
| e. Холимог тогтолцоо | 5. Санал хураалт явуулах замаар хийж байгаа улс төрийн сонголт |

2.4 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)

(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|--------------------------------|---|
| a. Зах зээл | 1. Хоорондоо ялгаатай боловч нэг төрлийн бараа таваар борлуулахыг сонирхсон олон тооны үйлвэрлэгчид байгаагаар тодорхойлогддог зах зээлийн төлөв байдал |
| b. Чөлөөт өрсөлдөөний зах зээл | 2. Бүх буюу ихэнх үйлдвэрлэлийг хяналтандаа аваад бараа болон үйлчилгээний үнэнд нөлөөлж болох боломжийг олсон зах зээлийн бүтэц |
| c. Олигополь зах зээл | 3. Бие биеэ орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг цөөн тооны үйлдвэрлэгчтэй зах зээлийн төлөв байдал |
| d. Монопольт өрсөлдөөний зээл | 4. Зах зээлийн пүүсүүд нөлөө үзүүлж чаддаггүй, зах зээлд чөлөөтэй орж, гарч чаддаг, мэдээлэл төгс байдаг зах зээл |
| e. Монополь зах зээл | 5. Бүтээгдэхүүн болон үйлчилгээ, үйл ажиллагааны үр дүнг солилцохын тулд үйлдвэрлэгч, хэрэглэгч нар үнэ, тоо хэмжээг тодорхойлж харилцан ажиллах хүрээ |